

**ШҮДТЭЙ ХОЛБООТОЙ НЭР, ХЭЛЛЭГЭЭС
ҮНДЭСТНИЙ СЭТГЭЛГЭЭНИЙ ОНЦЛОГИЙГ АЖИГЛАХ НЬ**

Ц.Онон *

Үг нь тогтсон нэг утгатай байхаас гадна хэлний хөгжил, хэрэглээний явц, нийгэм соёлын хөгжлийн өөрчлөлтийг даган хувирч өөрчлөгдсөөр салбар салаа утгатай болдог бөгөөд бид энэхүү өгүүлэлдээ шүд орсон нэр болон хэлц хэллэгийг сонгон авч, утга, үндэстний сэтгэлгээний онцлогийг ажиглахыг зорилоо.

Have teeth (шүдтэй)-хүч чадалтай, ууртай, *Toothless*(шүдгүй)-эрх мэдэлгүй, *歯を出す* (шүдээ гаргах) -уурлах, загнах, *Араандаа зуух*-хорсож зангах, Ам шүдээ билүүдэх-хов хутгах,хэл ам хийх гэхчлэн ихэнх хэлнээ шүд орсон хэллэгүүд уур хилэн, хорсол занал гэх мэт сөрөг үнэлэмжийг илэрхийлж байдаг нь шүд хүн төрөлхний хувьд хамгийн анхны зэвсэг, айдас төрүүлэхүйц зүйл байсантай холбоотой бизээ.

Эрт цагаас нааш хамгийн чухал эрхтэн байж ирсэн хүний гучин хоёр шүдийг байрлалаас нь шалтгаалан бид үүдэн *шүд*, *соёо*, *араа*, *агт араа* гэж нэрлэдэг. Энэхүү шүдний нэрлэлт нь түүний үүрэг, тухайн үндэстний ахуй соёлоос шалтгаалан өөр өөр, өвөрмөц онцлогтой байх бөгөөд тухайлан өөрийн судалдаг япон хэлний жишээг авч үзвэл, үүдэн *шүдийг* 前歯 (урд шүд) 門歯 (үүдэн шүд) 切歯 (таслах шүд), *соёог* 犬歯 (нохой шүд), 糸切り歯 (утас таслах шүд), *арааг* 奥歯 (арын шүд) 臼歯 (үүрдийн шүд), *агт арааг* 親知らず (эцэг эх мэдэхгүй) хэмээн нэрлэдэг.

Шүдний нэрлэлтээс нэлээд сонирхол татаж байгаа нь агт араа бөгөөд эрт дээр цагт мах идэхэд зориулагдсан маш хэрэгтэй шүд байсан ч бидний тархи томорч эрүүний ясны хэлбэр өөрчлөгдсөнөөр төдийлөн үүрэггүй болсон гэж үзэж байгаа энэ шүдийгангли хэлнээ *wisdom tooth*, *eyetooth*, орос хэлнээ *зуб мудрости* гэж нэрлэдэг нь бие гүйцэж, ухаан тэгшрэх үед ургадагтай холбоотой аж. Монголчууд ч мөн арван гуравны агт араа ургамагц эрийн цээнд хүрлээ гэж хөвгүүдийг, эхнэрийн зэрэгт хүрлээ гэж охидыг тооцдог байсан цаг дээр үед байжээ хэмээн Л.Түдэв “Арван нэгийн эргүүлэг”¹ өгүүлэлдээ дурдсан байдаг. Япон хэлнээ энэ шүдийг 親知らず (эцэг эх мэдэхгүй) гэж нэрлэсэн нь эрт цагт япончууд тун богино насалдаг, агт араа нь ургах үед

* МУИС-ийн МХСС-ийн Гадаад хэлний тэнхим

¹ Л.Түдэв “Арван нэгийн эргүүлэг”, Дал сонин, дугаар 292 /3

тухайн хүний эцэг эх нь хэдийнэ нас барсан байдагтай холбоотой. Японд ч мөн эрт цагт агт араа ургахад нас биед хүрлээ гэж үздэг байсан гэх бөгөөд энэ үед お齒黒 хэмээх эмэгтэй хүний шүдийг хараар будах заншил байж, хамаатан садандаа нэр хүндтэй ахмад эмэгтэйг урин шүдийг нь будуулдаг байжээ.

Монгол хэлнээ шүдтэй холбоотой *шүдлэх, шүдлэн, Бэлгийн морины шүдийг үздэггүй, цахиур нь цухуйх* гэх мэт хэллэг элбэг таардаг. *Шүдлэх* гэвэл хүн малын шүд ургах, мөнөөр нэг утгаар адуу малын насыг үзэж шалгах гэсэн утга бий. Малын нас шүдийг үзэхдээ түүний үүдэн шүднийх нь халбагын тоогоор үздэг бөгөөд адууныхыг бол шүднийх нь хээ угалзаар үзэж мэддэг. Мөн *шүдлэн* гэвэл гурван настай бод, хоёр настай бог малыг хүйс ялгалгүй нэрлэх нэр бөгөөд таван хошуу мал шүдлэн насандаа сүүн шүдээ гээж, ясан шүд ургадаг. Ийнхүү мал амьтны насыг шүдээр нь мэддэг ёс зөвхөн мал аж ахуй эрхлэн нүүдэллэн аж төрж ирсэн монголчуудад л бий агаад үүнээс үүдэн *Бэлгийн морины шүдийг үздэггүй* гэсэн хэллэг гарсан байна.

Монгол хэлний халхын салбар аман аялгуунд үгийн эхэнд орсон хэлний угийн гийгүүлэгч, хэлний урдуурх гийгүүлэгчтэй сэлгэдэг. Баянхонгор, Өвөрхангай аймгийн зарим нутгийн аялгуунд *и* эгшгийн өмнө орсон үгийн эхний *х* гийгүүлэгч хэлний урдуурхи *ш* гийгүүлэгчтэй, мөн буриад аялгуунд амьсгалын түрэлттэй үгийн эхний *х* гийгүүлэгч *ш* гийгүүлэгчтэй сэлгэдэг боловч үгийн утгад өөрчлөлт үл гардаг². Авиа сэлгэх энэхүү ёсоор шүд (*sidu*) нь хядах (*kiduqu*) гэсэн үгтэй нэг язгууртай болох бөгөөд алах шудах гэсэн хэлц хэллэг өнөө хэр хэрэглэгдсээр байна. Ийнхүү шүд нь алж хяддаг аймшигтай зүйл байсан учраас монголчууд нялх хүүхдийн шүд гарахыг шүд гэлгүй цээрлэн, *цахиур нь цухуйх* гэж хэлдэг.

Хатуу ааруул, мах идэж хэрэглэж ирсэн монголчуудад шүд хурц хатуу, бат бэх байх нь чухал агаад хүүхдийн сүүн шүд унахад түүнийг нь өөхөнд боон, “*Өөрийн сайн шүдийг өгөөрэй*” хэмээн залуу нохойд шидэж өгдөг. “*Залуу хүн идэрхэг, залуу нохой шүдэрхэг*” хэмээдэг монголчуудын хувьд нохой нь хурц шүдтэйн дээр, гэр малаа хамгаалдаг, хойд төрөлдөө хүн болж төрнө хэмээн үзэн хүндэлдэг амьтан. Тиймээс хамгийн ойр байдаг хоточ нохой нь шүдийг нь идвэл бат бөх сайн шүд урган, эрүүл саруул байна гэж итгэдэг байж. Харин японы зарим нутагт шүдийг эд баялагтай холбож, шүд том байвал элбэг хангалуун, жижиг байх тусам эд хөрөнгө, идэж уухаар хомс байна гэж үздэг. Японд хүүхдийн сүүн шүд унахад, доод талын шүд бол дээвэр лүү, дээд талын шүд бол доошоо шалны хөндий рүү шиддэг нь шүд аль болох сайн урган, том болохыг бэлгэдсэн үйл болох бөгөөд аливаа юм заавал анх байсан зүйл рүүгээ тэмүүлдэг гэж үздэг тэд ийн шидэхдээ доод шүд бол “*Чөтгөрийн шүдтэй солигд*”, харин дээд шүд бол “*Хулганы шүдтэй солигд*” хэмээн уг хүүхдээр нь хэлүүлж, өөрөөр нь шидүүлдэг нь үлгэр домгийн амьтан болох чөтгөр, загасны тор мэргэ урдаг хулганы шүдийг хамгийн хурц, том хэмээн итгэж ирсэнтэй нь холбоотой аж.

Монголчуудтай адил хатуу мах иддэггүй, ногоо загас гэх мэт зөөлөн зүйл иддэг ч япончууд юмыг сайн зажилж идэх дуртай. Идэх юм цэвэр, шинэ байх тусмаа зажлууртай байдаг гэх бөгөөд үүнээс үүдэн сонирхолтой, үр өгөөжтэй зүйлийг *шүдэнд хариутай* буюу *зажлууртай* (歯応えがある), ярьж суухад урамтай, сонирхолтой хүнийг *зажлууртай хүн* (歯応えのある人) гэж хэлдэг. Түүнчлэн юмыг сайн зажилж иддэгтэй холбоотой “*Амттай сархад охидын амнаас гардаг*” (美味しいお酒は乙女の口から) гэсэн

²⁾ Цолоо.Ж, “Орчин үеийн монгол хэлний авиа зүй”, Уб, 1976, 131-р тал

сонирхолтой хэллэг байна. Эрт цагт японд архийг зажилж хийдэг байж. Тутрагыг удаан захлах тусам шүлсэн дэх сахарын нөлөөгөөр түүнд агуулагдах цардуул нь чихэрлэг амттай болж, нэлээнажилсан тэр зүйлээ амнаасаа гарган саванд хийж орхиход тэр нь агаар дахь исгэгч бодисын нөлөөгөөр исэлдэн архи болдог байсан бөгөөд тэрхүү тутрага захлах нь цэвэр ариун, бага залуу охидын ажил байснаас ийм хэллэг гарсан байна. Энэхүү эртний аж үйлийг эс мэдвээс, уг хэллэгийн утгыг зөв ойлгоход бэрх болох юм.

Шүд орсон хэллэгийн тухайд олон хэлэнд нийтлэг ажиглагдаж байгаа өөр нэг зүйл бол шүднийхээ цаана юм нуух гэсэн санаа байна. Шүд шүдэн дундаа араа шүд нь үүдэн шүд, соёо шүд шиг унадаггүй учраас найдвартай гэж үзэх үзэл *араандаа сэлэм*(奥歯に剣), *араандаа зуух*, *араандаа хадгалах*(奥歯に隠す) гэх мэт жишээнээс харагдаж байна.

Мөн японы зарим нутагт шүд нь гэр бүл, ургийн хүмүүсийг зааж, илэрхийлж байдаг гэх бөгөөд баруун талын шүд эрэгтэй хүнийг, зүүн талын шүд эмэгтэй хүнийг, улмаар шүд нь урагшлах тусмаа залуу хүнийг, арагшлах тусмаа настай хүнийг зааж, шүд унаж байна гэж зүүдлэх нь тухайн хүнээс хагацахын дохио гэж үздэг. Найдвартай итгэлтэй зүйл болон гэр бүлээ араа шүдтэй холбон үзэхтэй холбоотой “*Эцэг эх нь араагаараа хаздаг хүүхдийг бусад хүн үүдэн шүдээрээ хазна*” (親の奥歯で噛む子は他人が前歯で噛む) гэсэн хэлц япон хэлэнд байна. Уг хэлц хэллэг нь монгол хэлний “*Эрхийг сурахаар бэрхийг сур*” гэсэн хэлцтэй ойролцоо буюу хүүхдээ эрхлүүлж байснаас ажил хөдөлмөрт сургасан нь дээр гэсэн утгатай. Чухам яагаад ийн хэлэх болов гэдгийг дараах байдлаар тайлбарлаж болох юм. Үүнд, шүд нь хүн төрөлхтний хувьд хамгийн анхны зэвсэг, айдас төрүүлэхүйц зүйл байсан гэдгийг дээр дурдсан билээ. Тиймээс араагаараа хазсанаас үүдэн шүдээрээ хазах нь илүү их өвтгөдөг гэдгийг мэдэрсэн эртний хүмүүсийн ул мөрийг энэхүү хэлц хэллэгээс олж харж болно. Түүнчлэн араа шүд хувирч өөрчлөгддөггүй бөгөөд юуг ч бяцалж няцалж чадах хүчтэй атал төдийлөн өвтгөөд байдаггүй өгөөмөр чанарыг нь эцэг эхтэйгээ, эцэг эхийнхээ хайртай зүйрлэсэн тухайн үндэстний сэтгэлгээний онцлогийг ажиглаж болохоор байна.

Дүгнэн үзвэл, шүд нь хүн бүхэнд адил тэгш байдаг эрхтэн хэдий боловч үндэстний сэтгэлгээ, ахуй соёлын өвөрмөц байдлаас шалтгаалан шүд орсон хэллэгийн илэрхийлж буй утга нь харилцан адилгүй байна. Энэ мэт нэр, хэлц хэллэг нь соёл сэтгэлгээний онцлогийг тусгаж байдаг учраас тухайн хэллэгт яв цав тохирох хэллэг нөгөө хэлэнд байдаггүй, утга дүйх ижил төсөөтэй хэллэг байдаг ч хэрэглээ нь ялгаатай байдаг тул хэлц хэллэгийг судлан, орчуулахдаа тухайн хэллэгийн цаана орших соёл сэтгэлгээний онцлогийг тодруулах, зөвөөр тайлбарлан тодорхойлох нь цаашид анхаарах ёстой зүйл болж байна.

НОМЗҮЙ

1. Аким Г (2001), *Монгол зүйр цэцэн үгийн тайлбар толь*, Улаанбаатар.
2. Бат-Ирээдүй Ж (2008), *Монгол хэлц үг, хэллэгийн утга хэрэглээ*, Улаанбаатар.
3. Баянсан Ж, *Хэл, соёл, үндэстний сэтгэлгээ*, Улаанбаатар.
4. Онон Ц, Чулуунбаатар Л (2010), *Япон монгол хэлний өвөрмөц хэлцийн толь*, Улаанбаатар.
5. Цолоо Ж (1976), *Орчин үеийн монгол хэлний авиа зүй*, Улаанбаатар.

6. ЦЭВЭЛ Я(1966), *Монгол хэлний товч тайлбар толь*, Улаанбаатар.
7. Baker M (2002), "In Other Words: A coursebook on translation" London and New York.
8. “故事ことわざ・慣用句辞典”三省堂編修所, 1999
9. “ことわざ辞典”岩波書店, 2000

SUMMARY

The soul of the word is its meaning that reveals the development of the real world through the language which is used for. A word has a definite meaning, in fact, but can be determined by more different meanings based on many factories like language development, process of word usage and social cultural changes. One of these features is focused on idioms.

As a result, we attempted to analyze the national mentality from some proper nouns and idioms which are formed by a word, used “TOOTH” through this article.

Why we have chosen this word in this article is related to the view that the tooth was the first tool or weapon and a thriller for humanity. So in many countries, “TOOTH” represents anger, jealousy, and other similar negative emotions.

But everything is multi-sided and has several features. They have either positive or negative evaluations which are depended on how to be studied. In which situation and for which purpose the idioms are used, are the most important for their evaluations, particularly for the world-view of the nationalities.

According to the idioms, the “TOOTH” represents not only the negative evaluation also the strength like a stone in Mongolian language. But the Japanese consider the ‘TOOTH’ in connection to their family, wealth and health.

Eventually, all human beings have the “TEETH”. But they use the word “TOOTH” for the evaluation of anything in different ways.